

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтвортжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын 5 дахь ашиглалт гарлаа**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өргийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлагах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрийн 5 дахь транчаар хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан “Шунхлай” ХХК-д жилийн 3.8%-ийн хүйтэй, 1 жилийн хугацаатай **21.4** тэрбум төгрөгийн санхүүжилтийг өнөөдөр шилжүүллээ.

Түүнчлэн дэд хөтөлбөрт заасны дагуу Монголбанк нь оролцогч банкаар дамжуулан “Шунхлай” ХХК-д нийт 21.4 тэрбум төгрөгтэй тэнцэх амдолларыг **2** сарын дараа худалдах форвард хэлцлийг хамгийн бага зардлаар гүйцэтгэж, ханшийн эрсдлийг нь буурууллаа.

Ийнхүү зээлийн шугамын болон санхүүгийн үүсмэл хэрэгслийн гэрээгээ оролцогч банкуудтай байгуулсан хэрэгжүүлэгч **5 компани нь нийтдээ 62.8** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг ашиглаад байна.

Дэд хөтөлбөрийн өмнөх ашиглалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны “Үнийг тогтвортжуулах хөтөлбөр” цэснээс үзнэ үү. <http://www.mongolbank.mn/pricestability.aspx>

--- oOo ---